



# СОЁМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№110 /110/

2021.08.11

## ҮЙЛ ЯВДАЛ

### У.Хүрэлсүх: ЭХ ОРНЫХОО НЭР ХҮНДИЙГ ӨНДӨРТ ӨРГӨСӨН ТА БҮХЭНД ЧИН СЭТГЭЛИЙН ТАЛАРХАЛ ДЭВШҮҮЛЬЕ



Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад явагдсан олон үндэстний "Шийдвэртэй дэмжлэг" ажиллагаанд АНУ болон ХБНГУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багуудын бие бүрэлдэхүүнд төрийн одон, медаль, салбарын шагнал гардуулах ёслолын ажиллагаа өчигдөр боллоо.

Энэхүү ёслолын арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Ухнаагийн Хүрэлсүх, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Ж.Энхбаяр, Ерөнхийлөгчийн аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх, бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоо, Зэвсэгт хүчний Жанжин цэргийн командлагч нар, цэргийн багуудын бие бүрэлдэхүүн оролцсон юм. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Цэргийн гавьяаны одонг Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабындарга, хошууч Э.Амартүвшин, Цэргийн хүндэт медалийг ЗХЖШ-ын Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн, дэд хурандаа М.Түвшинжаргал, "Энхийн төлөө" медалийг Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албаны зохицуулагч, ахлах ахлагч М.Сумъяа, Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн замын тусгай ротын операторчин, ахлагч Н.Энхжин, 142 дүгээр ангийн хөгжимчин, дэд ахлагч Б.Цогбадрах нарын 17 хүнд хүртээсэн юм. Мөн Батлан

хамгаалахын сайдын тушаалаар "Афганистанд энхийн төлөө I, II, III" дурсгалын тэмдгээр Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн танкийн батальоны ажиллагааны офицер, ахмад Д.Өсөхбаяр, 013 дугаар ангийн ротын захирагч, ахмад Ж.Билгүүн, холбооны ротын ахлагч, ахлах ахлагч Ш.Жамсран, 014 дүгээр ангийн тасгийн захирагч, ахлагч Б.Баасандорж, 330 дугаар ангийн гранатомётчин, ахлагч Г.Анххуяг нарыг шагналаа. Төрийн одон, медаль болон салбарын шагнал гардуулах ёслолын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх "Түүхийн бүхий л үед монгол цэрэг нь төр, улсынхаа тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, халдашгүй дархан байдал, эрх чөлөөт ард түмнийхээ энх амгалан оршихуйн баталгаа, мандан бадрахын бэлгэ тэмдэг байсаар ирсэн. Өнөө үеийн монгол цэргүүд өвөг дээдсээсээ өвлөсөн дайчин уламжлалаа нэр төртэй үргэлжлүүлж, хүн төрөлхтний өмнө төр, улсынхаа хүлээсэн үүргийг амжилттай биелүүлж, НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын цэргийн ажиллагаанд идэвхтэй оролцож, монгол эх орон, монгол цэргийнхээ нэр хүндийг өндөрт өргөж буйг тэмдэглэн хэлэхэд таатай байна. Та бүхэн цагийн байдлын болон цаг агаарын хүнд нөхцөлд мэргэжлийн өндөр ур чадвар, эр зориг, тэсвэр хатуужил, сахилга, зохион байгуулалтаараа бусад улс орны цэргийн алба хаагчдад үлгэр жишээ үзүүлэн, эх орныхоо нэр хүндийг өндөрт өргөсөнд баяр хүргэж, чин сэтгэлийн талархал дэвшүүлье" гэв.

## МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм генерал, офицер, ахлагч, ажилтан албан хаагч, хилийн чанадад үүргээ нэр төртэй гүйцэтгэж буй энхийг сахиулагч, эх орноо батлан хамгаалах үйлсэд хөдөлмөр зүтгэл, залуу насаа зориулсан бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид Та бүхэнд Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэргийн өдрийн мэндийг өргөн дэвшүүлье!

Одоогоос 57 жилийн тэртээ БНМАУ-ын Ардын цэргийн хэрэг эрхлэх яамны сайд бөгөөд Ардын Армийн командлагчийн 1964 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн тушаалаар "Армийн артиллерийн дивизион", "Армийн радиотехникийн тусгай батальон"-ыг байгуулсан нь одоогийн Зэвсэгт хүчний 065, 325, 353 дугаар ангийн үндэс суурь болсон бөгөөд энэхүү өдрийг Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэргийн өдөр хэмээн тэмдэглэсээр ирсэн юм. Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэрэг нь хуулиар хүлээсэн эх орныхоо агаарын хилийн халдашгүй дархан байдал, агаарын зайд хяналт тавих, хамгаалах үүргээ нэр төртэй гүйцэтгэсээр ирснийг баярын энэ өдөр онцлон тэмдэглэе.

Дэлхийн ихэнх улс орон Зэвсэгт хүчнийхээ Агаарын цэргийг хөгжүүлэх, агаар-сансрын орон зайгаа бүрэн хянах, агаар-пуужингийн довтолгооноос хамгаалах чадвархаа нэмэгдүүлэхэд онцгой анхаарч байгаагийн нэгэн адил Монгол Улсын төр, засаг, цэргийн дээд удирдлагаас Агаарын цэргийн бие бүрэлдэхүүнийг мэргэшсэн, чадварлаг болгон хөгжүүлэх, зэвсэглэл, техникийг үе



шаттайгаар шинэчлэх, сэргээн сайжруулах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Зэвсэгт хүчний шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл хэрэгт цаг ямагт манлайлан, хувь нэмрээ оруулж буй Агаарын цэргийн нийт бие бүрэлдэхүүн, үе үеийн ахмад дайчид Та бүхэндээ дахин баярын мэндчилгээ дэвшүүлж, ажил үйлсэд тань арвин их амжилт, аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг бэлгэдэн өрөөе.

Монгол Улсын агаарын хил өнө мөнхөд халдашгүй дархан байх болтугай!

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ



Эх орныхоо цэлмэг хөх тэнгэрийг тольдон харж, сахин хамгаалах агаарын харуулчдын бахдам сайхан албыг үргэлжлүүлж байгаа Зэвсэгт хүчний Агаарын цэргийн нийт бие бүрэлдэхүүнд болон Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн хөгжил дэвшил, хойч үеийнхээ ирээдүй, тэднийг сурган хүмүүжүүлэх ажилд хөдөлмөрлөн зүтгэж ирсэн ахмад буурлууд Та бүхэндээ Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэргийн 57 жилийн ойн

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ ХОШУУЧ ГЕНЕРАЛ О.ЭНХБАЯР

баярын мэндийг хүргэе. Тэртээх 1964 оны 8 дугаар сард 11-ний өдөр БНМАУ-ын Ардын цэргийн хэрэг эрхлэх яамны сайд бөгөөд Ардын Армийн командлагч, хурандаа генерал Ж.Лхагвасүрэнгийн тушаалаар ААЕШ-ын Пуужин ба артиллерийн албаны харьяанд Агаараас эсэргүүцэн хамгаалах пуужингийн тусгай дивизион, радиотехникийн тусгай батальон байгуулагдаж 24 цагийн "байлдааны жижүүрлэлт"-ийн үүргээ гүйцэтгэж эхэлснээр одоогийн агаарын довтолгооноос хамгаалах цэргийн үндэс суурь тавигдсан түүхтэй.

Радиотехникийн болон Зенит-пуужингийн ангиуд нь байлдааны харвалттай тактикийн хэргийн сургуулийг Монгол Улсын нутаг 3, ЗХУ-ын нутаг 14 удаа явуулж, байлдааны пуужингийн харвалтыг нийт 17 удаа онц дүнтэй гүйцэтгэн, Ардын Армийн тэргүүний онц ангиар удаа дараа шалгарч байсан бахархам түүх бидэнд бий. Агаарын цэргийн үе үеийн агаарын харуулчид, офицер, ахлагч, ажилчин алба хаагч нарт Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэргийн 57 жилийн ойн баярын мэндийг дахин дэвшүүлж та бүхэнд өнөөг хүртэл олсон амжилтаа улам бататгаж, цэргийн мэргэжлийн ур чадвараа улам сайжруулж ямагт манлайлагч байхын ерөөлийг өргөн дэвшүүлье

## ЦАГ АГААР

### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 24	🌧️ 7

### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 30	🌧️ 23

## ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.850.0	2.852.0
EUR 🇪🇺	3.55.0	3.375.0
CNY 🇨🇳	440.5	441.3
RUB 🇷🇺	38.20	39.30
JPY 🇯🇵	25.60	26.04
KRW 🇰🇷	2.44	2.53

## ЗУРХАЙ

2021.08.11 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 3/

**НАМРЫН ТЭРГҮҮН УЛААН БИЧ САРЫН НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ТУУЛАЙ ӨДӨР**

Үс засуулбал:

Эд мал баялаг төгөлдөр болно Наран ургах, шингэх: 05:41-20:15

Барилдлага:

Үл зохилдох

Шүтэн барилдлага:

Сансар

Суудал:

Хий

Энэ өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой.

Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. /муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/, бурханы ёс ба тарни бүтээх, амраг нөхдийг хураахуйд сайн. Баруун чих хангинавал асрагдах, зүүн нь бол буян арвижих, нохой уливал гэрийн тэнгэр зайлсан, хэрээ гуаглавал эд агуурс олдох, тагнай загатнавал зочин ирэх, бие татвал гаслан болох, хөл татвал хувцас олдоно

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН	ЭДГЭРСЭН	НАС БАРСАН
175,560 +957	157,616 +1991	860 +3

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
4266 +78	168 +27	4016 +10

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол	Нийт: 204,722,254
Эдгэрсэн	Нийт: 183,852,4219
Нас барсан	Нийт: 4,325,691

**ДЕЛЬТА ХУВИЛБАР**  
АНХЛАРАХ ШИНЭ ШИНЖ ТЭМДЭГ

- Суулгах
- Хамар битүүрх, нус гоожих
- Буцлин өвдөх
- Урт хугацаагаар толгой өвдөх
- Бөөлжих
- Хоолой өвдөх
- Бие тавгүйрх, идрах

ДЭЭРХ ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРВЭЛ ШИНЖИЛГЭЭ ӨГӨӨРЭЙ.

## ӨНӨӨДӨР УЛСЫГ АГААРЫН ДОВТОЛГООНООС ХАМГААЛАХ ЦЭРГИЙН ӨДӨР

### ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АГААРЫН ЦЭРГИЙН ТОВЧ ТҮҮХЭЭС

Ардын Цэргийн Хэрэг Эрхлэх Яамны Сайд бөгөөд Командлагчийн 1964 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн Н/174 дүгээр тушаалаар Улсыг Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн анхны 028, 065 дугаар ангиуд байгуулагдсан түүхтэй.

1964 оны 8 дугаар сарын 11-ний өдөр Ардын Цэргийн Хэрэг Эрхлэх Яамны сайдын Н/174 дүгээр тушаалаар "Армийн радиотехникийн тусгай батальон" нэртэйгээр Улаанбаатар хотын орчим Улиастайн аманд байгуулж 1965.9.1-ний өдрөөс 24 цагийн "Байлдааны жижүүлэлт"-д шилжсэнээр эх орныхоо цэлмэг хөх тэнгэрийг тольдон харж, сахин хамгаалах "Агаарын харуулчдын" бахдам



хүчний 353 дугаар ангийг шинээр байгуулсанаас хойш Зенит-пуужингийн ангиуд нь байлдааны пуужингийн харвалтыг 17 удаа онц дүнтэй гүйцэтгэсэн. Ардын Армийн Зенитийн пуужингийн 028 дугаар анги 1964 онд, 134 дүгээр анги 1970 онд тус тус байгуулагдаж, Улсын

байгуулж, ОХУ-аас буцалтгүй тусламжаар нийлүүлсэн зенитийн пуужингийн цогцолборыг зэвсэглэлдээ хүлээн авсан ба нийслэл хотыг агаараас халхлах үүрэгтэйгээр байлдааны жижүүлэлтийн үүрэг гүйцэтгэж байна. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн үе



сайхан албыг гүйцэтгэж эхэлсэн түүхтэй. 1969 оны 7 дугаар сарын 15-ны өдөр БНМАУ-ын БХЯ-ны сайдын тушаалаар тус батальоныг "Радиотехникийн тусгай хороо" болгон өргөтгөж 2002 онд Монгол Улсын төрийн цэргийн бодлого, Монгол Улсын Засгийн Газрын хөтөлбөр, Зэвсэгт хүчнийг чадварлаг болгох бодлогын хүрээнд ижил төстэй ангиудыг бүтэц, зохион байгуулалтаар нэгтгэх бодлогоор ЗХЖШ-ын даргын 257 дугаар тоот тушаалаар Зенитийн пуужингийн 028 дугаар ангитай нэгтгэн "Пуужин-радиотехникийн хороо" болгон зохион байгуулсан.

2011 онд Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Батлан хамгаалахын сайдын болон ЗХЖШ-ын даргын тушаалаар ангийг "Радиотехникийн хороо"-ны шинэ бүтцэд шилжүүлж, тус ангиас зенитийн пуужингийн дивизионыг салган Зэвсэгт

нийслэл, онц чухал объектын агаараас халхлах үүрэгтэйгээр байлдааны жижүүлэлтийн үүргийг гүйцэтгэж эхэлсэн. Энэ хугацаанд байлдааны харвалттай тактикийн хээрийн



сургуулийг Монгол Улсын нутаг дэвсгэрт 3 удаа, ЗХУ-ын нутаг дэвсгэрт /хуучин нэрээр/ нийт 14 удаа явуулж, тогтмол сайнаас онц дүнтэй буудаж байсан ба Ардын Армийн тэргүүний онц ангиар удаа дараа шалгарч байв. Өдгөө тус ангийн суурин дээр Зэвсэгт хүчний 353 дугаар ангийг 2012 онд шинээр

үеийн цэргийн алба хаагчдын алдар гавьяаг мөнхжүүлэх, залуу хойч үеийг эх оронч үзлээр хүмүүжүүлэх, Агаарын цэргийн үйл ажиллагааг сурталчлах, ажлын туршлага

солилцох, бүтээлч үйл ажиллагааг хөгжүүлэх зорилгоор Батлан хамгаалахын сайдын 2013 оны тушаалаар 8 дугаар сарын 11-ний /Ардын армийн радиотехникийн тусгай батальон байгуулагдсан/ өдрийг Улсыг Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн өдөр болгон тэмдэглэж ирсэн түүхтэй.



## СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд 2021-2022 онд үүрэг гүйцэтгэх цэргийн ажиглагч офицер, штабын ажилтны сонгон шалгаруулалтыг 2021 оны 9 дүгээр сарын 20-ноос 24-ны өдрүүдэд зохион байгуулна.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй цэргийн алба хаагчид

2021 онд шинээр батлагдсан "Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах журам"-тай танилцаж, НҮБ-ын цэргийн

ажиглагч, штабын ажилтанд тавигдах шаардлагыг хангасан байх ба ЗХЖШ-ын АУГ-ын Энхийг дэмжих ажиллагааны хэлтэст доорх материалыг бүрдүүлэн 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ. Үүнд:

1. Харьяа анги, байгууллага, төрлийн цэргийн командлал болон ЗХЖШ-ын бүтцийн нэгжийн удирдлагын зөвшөөрсөн цохолттой хувийн өргөдөл;
2. Ажил байдлын тодорхойлолт
3. Жолооны үнэмлэхний хуулбар;

4. Цэргийн ажиглагч, штабын офицерын сургалт, дамжаа дүүргэсэн сертификатын хуулбар;

5. Сүүлийн 3 сарын дотор авахуулсан 4х6 хэмжээтэй цээж зураг 2 хувь.

6. Товч судалгаа  
7. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт

Жич: Шаардлагатай нэмэлт мэдээллийг АУГ-ын ЭДАХ-ийн psod@mil.gov.mn цахим шуудангаар болон /3203, 92115982/-тэй холбогдож тодруулж болно.

### ЗХЖШ-ЫН АУГ-ЫН ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС

## МОНГОЛЫН ХАМГИЙН АНХНЫ АГААРЫН ДҮҮЖИН РЕСТОРАН




Их тэнгэрийн амаас зүүн тийш хоёр км зайтай байрлах "Туул гарден"-д "UB in the Sky" агаарын дүүжин ресторан нээгджээ.

Тус ресторан нь кранаар өргөгдсөн бөгөөд 45 метрийн өндөрт байрладаг аж.

Нэг удаадаа 18, нэг өдөрт 200 орчим хүн хүлээн авах чадалтай бөгөөд ирсэн зочдоос гадна 4-5 хүн ажилладаг байна. Рестораны гол хэсэгт тогооч, зөөгч, комедиан, аюулгүй албаны ажилтан ажиллаж, зочдыг хамгаалалтын бэхлэгээтэй суудалд суулгаж, хотын нөхцөл байдлыг агаар дээрээс тольдонгоо тансаг зэрэглэлийн үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Тус ресторанаар нэг цаг үйлчлүүлэх нэг хүний төлбөр нь 200 мянган төгрөг. Үүнд, амьд хөгжим эсвэл комедиан сонголтоор, европ хоол, зууш, десерт, уух зүйлс багтжээ.

## НАРНЫ СОРОНЗОН ШУУРГААС БОЛГООМЖИЛ



Энэ 8 дугаар сард хүн төрөлхтөн хэд хэдэн хүчтэй соронзон шуурганд өртөх юм байна. Ялангуяа, цаг агаарын үзэгдэлд хэт мэдрэмтгий хүмүүст хэцүү үе тохиох юм.

Сарын дундуур нарны идэвхжил хамгийн ихээр явдагдах бөгөөд үүнд бэлтгэлтэй байхыг мэргэжилтнүүд анхааруулж байна. Нарны идэвхжил зуны сүүлчээр болно гэсэн таамаг байсан.

Эхний соронзон шуурга 8 дугаар сарын 2-3-ны өдрүүдэд болсон. Ер нь нар, сар, од гарагийн нөлөө хүний биед шууд утгаараа нөлөөлдөг. Ялангуяа, зүрх судасны өвчтэй хүмүүс энэ үеэр илүү болгоомжтой байхыг зөвлөдөг. Энэ удаагийн соронзон шуурга нэг их хүчтэй

болхгүй учир бусад хүнд бараг мэдрэгдэхгүй өнгөрөх аж.

Харин өчигдөр буюу 8 дугаар сарын 10-нд нэлээд хүчтэй соронзон шуурга болсон талаар мэргэжилтнүүд мэдээлсэн юм. Энэ үеэр нарны идэвхижил түвшний хувьд дундаж байсан бөгөөд нөлөө нь цаг агаарын үзэгдлээс хамаарч бие нь тавгүйрхдэг бүх хүмүүст нөлөөлжээ.

Наймдугаар сарын 13-14-ний хооронд соронзон шуурганы идэвхижил бага зэрэг буурах тул эрүүл мэндийн хувьд ч нэг их санаа зовох зүйлгүй юм байна. Энэ үеэр 8 дугаар сарын 16-20-ны хооронд болох дараагийн соронзон шуурганд харин бэлтгэлтэй байх нь зүйтэй. Энэ өдрүүдэд толгой хүчтэй өвдөх, сэтгэл санааны байдал тогтворгүйтэх, үе мөч

янгинан өвдөх болон бусад тааламжгүй шинж тэмдгүүд илэрч болох юм байна.

Түвшний хувьд дунд зэргийн хүчтэй соронзон шуурга 8 дугаар сарын 29-нд тохиох ба энэ өдөр аль болохоор бие бялдрын болон сэтгэл хөдлөлийн аливаа стрессээс эмгид байж тайван амрахыг зөвлөж байна. Нарны соронзон шуургыг ямар нэгэн асуудалгүй давж гарахын тулд муу дадал зуршлуудаасаа татгалзаж, хоолны дэглэмээ ч эргэн харж, зарим нэг өвчин намдаах эм бэлдмэлийг гарын дор ойр байлгахыг мэргэжилтнүүд зөвлөж байна. Хэрэв биеийн байдал улам дордвол түргэн тусламж дуудах эсхүл мэргэжлийн эмчид хандах хэрэгтэй.

Эх сурвалж: planetanovosti.